



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/378

Ховд


Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тулгар төрийн 2229, Их Монгол улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ойн баярыг тохиолдуулан ард иргэдийнхээ амгалан, тайван амьдрах орчин бүрдүүлэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйлсэд үнэтэй хувь оруулан хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж буй Цагдаагийн газрын нярав Х.Мягмарсүрэн, Эрүүгийн мөрдөгч ахлах дэслэгч Б.Сүхцэрэн, Мөрдөгч ахлах дэслэгч Т.Сумъяа, Холбоо мэдээллийн инженер, дэслэгч Б.Мөнхтулга нарыг аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Х.Мягмарсүрэн, Б.Сүхцэрэн, Т.Сумъяа, Б.Мөнхтулга нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /Э.Даваасүрэн/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ